



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/301

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Онцгой комиссын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр орсон хүчтэй аадар борооны үерийн улмаас эвдэрсэн үерийн усны хамгаалалтын далан шуудуу, ус зайлуулах сувгийг сэргээн засварлах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Баярхүү	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Гишүүд:	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
	Ц.Идэрбат	Хэрлэн сумын Засаг дарга
	Б.Ганбат	Авто тээврийн төвийн дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Б.Батсайхан	Цагдаагийн газрын дарга
	Г.Батгэрэл	Хэнтий ус ТӨҮГ-ын захирал
	Ч.Болдбаатар	Харгуй ТӨК-ийн захирал

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА